

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)

Мэдээллийн эмхэтгэл №12 (2018 он 4-р сар)

ТББ-ын ажил

ТББ-ын ажлын сонгон шалгаруулалтанд оролцож материалаа өгөөд үзтэл азаар бичиг баримт маань тэнцэж, ярилцлаганд орохоор боллоо. Ярилцлаганд орсон 5 хүнээс 1 л хүнийг авна гэдгийг сонсоод санаа зовж байсан боловч Бүтээн байгуулалтыг судлах хичээлээр далан, дэд бүтцийг бий болгох нөлөө, ажлын талбар дээр нь очиж суралцах хүсэл гэх мэт өөрийн хүсэл зорилго, төгссөн сургууль, ажлын туршлагаа ойлгомжтой сайн тайлбарласан учраас тэнцэж чадлаа. Өмнөх ажлаасаа гараад 3 жилийн дараа анхны цалингаа авахаар боллоо. Хэдийгээр тийм ч өндөр цалин биш боловч би хувьдаа маш баяртай байсан юм. 1999 оны 1-р сард би 31 настайдаа Камбож улс руу анх удаагаа явлаа. Анх очиход хөгжиж буй орон гэдэг нь илт мэдэгдэж байсан ба нийслэл Пном Пен хот нь нэлээн тоос шороотой, Зүүн Өмнөд Азийн халуун нар шарсан, олон хүн холхилдсон, бүгчим халуун уур амьсгалтай газар байлаа. Камбожийн Ангкор Ват цогцолбор сүм маш алдартай бөгөөд нийслэл хотоосоо нэлээд зайтай, Тонле Сап (Tonle Sap) голоор усан онгоцоор 5-6 цаг явж байж очно. Дахин ТББ-ын ажлынхаа талаар өгүүлэхэд, Япон улсын Засгийн газар 1970-аад оны үед далан барих ажил эхлүүлсэн боловч дотоодын дайны улмаас бүтээн байгуулалтын ажил нь зогсож тэр хэвээрээ хаягдаж орхисныг дахин сэргээх тухай яриа гарсан байна. 70-аад онд далан барих үед хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг судлаагүй байсан тул дахин сэргээн засварлах тохиолдолд хүрээлэн буй орчны судалгааг хийх шаардлагатай болжээ. Засгийн газрын зүгээс хийсэн хүрээлэн буй орчны судалгаанд бүрэн дүүрэн итгэх боломжгүй учраас ТББ судалгаа хийж, санал дэвшүүлэх болсон байна. Улмаар тус судалгааг надаар хариуцан хийлгүүлэх хүсэлт тавьсан юм. Маш өндөр хариуцлагатай ажил хийх болсноо сонсоод надад бага зэрэг айдас төрсөн. (Үргэлжлэл бий...)



DPUB төслийн ахлах зөвлөх

Чиба Хисао

DET Сургагч багш бэлтгэх сургалтын мэдээллээс (2018.04.09-2018.04.25)

~Шинэ сургагч багш нар бэлтгэгдэн гарлаа~

11 өдрийн сургалт дуусаж, хамгийн сүүлийн хөтөлбөр болох Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын Сургагч багш бэлтгэх сургалтын төгсөлтийн арга хэмжээ зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд ХНХЯ болон ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын холбогдох албан хаагчид хүрэлцэн ирж оролцлоо. Арга хэмжээ эхлэх үед оролцогчид бага зэрэг биеэ барьсан байдалтай байсан. Хүн тус бүрийн нэрийг дуудаж, сертификат гардуулан дурсгалын зураг татуулсны дараа сургалтанд оролцогчдыг төлөөлж Нэмэхбаяр үг хэлсэн. “Өнөөдөр бид сургагч багшийн гараагаа эхлүүлж байна. Цаашид хүн бүрт хүртээмжтэй нийгмийг бий болгохын тулд үйл ажиллагаагаа явуулах болно.” хэмээн дохионы хэлээр ярьж, цаашид идэвхтэй үйл ажиллагаа явуулна гэдгээ хэллээ. Сургалтанд оролцогчид өнгө өнгийн гоёмсог дээлээр гоёж, нүүр дүүрэн инээмсэглэлтэйгээр төгсөлтийн арга хэмжээнд оролцлоо.



Сертификатаа гардаж авсны дараа дурсгалын зураг авахуулав.

~Ахлах сургагч багш ~



Ахлах сургагч багш нар

Энэ удаагийн Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын Сургагч багш бэлтгэх сургалтаар бусаддаа зөвлөгөө өгөх ахлах сургагч багш нарыг ч гэсэн бэлтгэлээ. Тэд бусад

хүмүүсээс арай урт нийт 13 өдрийн сургалтанд хамрагдсан. Сургалтын үеэрх лекц, дасгал ажлууд үр дүнтэй байгаа эсэх тал дээр анализ хийх, мөн сургалтанд оролцож буй сургагч багш нар агуулгыг хэр ойлгож байгаад хяналт тавих нь тэдний үүрэг байлаа. Тэд бүх хөтөлбөрт амжилттай оролцож, хамгийн сүүлийн өдөр Күно багшаас сертификатаа гардан авсан. Мөн цаашид бусад сургагч багш нартайгаа хамт үр дүнтэй DET сургалт хийхийн тулд хичээн ажиллана хэмээн өгүүлж байлаа. Эхний удаагийн болон 2 дахь сургалтаас нийт 32 сургагч багш бэлтгэгдэн гарсан бөгөөд тэдний дундаас сонгогдсон 6 ахлах сургагч багш цаашид улам илүү амжилт гаргана гэдэгт итгэлтэй байна.



JICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **1944** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

~Өдрийн хоолны үйлчилгээ~



Тэргэнцэртэй хүнд хүртээмжтэй үйлчилгээ

Сургалт өдөр бүр өглөөнөөс орой хүртэл шахуу хөтөлбөртэй үргэлжилсэн бөгөөд зарим өдөр гэрийн даалгавар өгч байсан. Гэхдээ сургалтанд оролцогчид өдрийн хоолны цагийг маш хөгжилтэй өнгөрөөж байлаа. Сургалт зохион байгуулагдсан газрын рестораны ажилчид тэдэнд зориулж буфет хоол тавих ширээний өндрийг намсгаж өгсөн юм. Жирийн ширээнээс бага зэрэг намсгах төдийд тэргэнцэртэй хүмүүс хоолоо өөрөө сонгож тавгандаа хийх боломжтой болсон. Хүнээс тусалцаа авалгүй өөрөө харж, сонгох боломжтой орчныг бүрдүүлэхийн тулд хэт өндөр ч биш, хэт нам ч биш ширээг сонгосноор бүх хүн ая тухтай үйлчлүүлэх орчин бүрджээ.

~Сургалтанд хамрагдсаны дараа би хэрхэн өөрчлөгдсөн бэ?~



Харилцан ярианы үеэр

Бүх лекц, дасгал ажил дууссаны дараа бүгд нэг тойрог болж суугаад “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын Сургагч багш бэлтгэх сургалтанд оролцсоны дараа хэрхэн өөрчлөгдөн бэ?” гэсэн сэдвийн дагуу харилцан ярилцлаа. Сургалтанд оролцогчид “Өнөөг хүртэл зөвхөн өөрийнхөө хөгжлийн бэрхшээлийн талаар л боддог байсан бол сургалтанд хамрагдсанаар бие эрхтний бэрхшээлтэй эсэхээс үл хамааран бүх хүмүүс тэгш оролцож чадах нийгмийг бий болгох юмсан гэж бодох болсон.” “Нийгэм өөрчлөгдөхийг хүлээхээс өөр арга байхгүй гэж бодож байсан боловч тус сургалтанд хамрагдсанаар би өөрөө өөрчлөх ёстой юм байна гэдгийг ойлгосон.” “Ирээдүйд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хүсэж байсан. DET сургагч багш болсноор би өөрийн мөрөөдлийг биелүүлэх боломжтой боллоо.” хэмээн өгүүлж байсан. DET сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй гээд 8 наснаас 80 насан хүртэл хамрагдах боломжтой сургалт юм. Бизнесийн байгууллага, төрийн байгууллага, сургууль...гээд хараахан өөрсдийн байгууллага дээр DET сургалтыг авч амжаагүй байгаа бол DET Форум Монгол (detforummongolia@gmail.com) ТББ-тай холбогдож, тус сургалтанд хамрагдаарай.

~ Зааварлагч багш ~

Энэ удаагийн Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын Сургагч багш бэлтгэх сургалтын үеэр бас нэг үйл явдал болсон нь “Зааварлагч багш бэлтгэх сургалт” байлаа. Өнөөг хүртэл ахлах сургагч багш байсан төслийн мэргэжилтэн Тэрүя зааварлагч багш бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан юм. Ингэснээр олон улсад бэлтгэгдсэн 6 дахь зааварлагч багш болж байна. Тэрээр Японы ЖАЙКА-ийн төв оффисоос ирсэн Күно багшийн зааварчилгаагаар 11 өдрийн бүх лекц, дасгал ажлыг хариуцан явуулсан. Сургалтын дараа Тэрүя мэргэжилтэн “Лекцийн үеэр Күно багш хойно ирээд Тэрүя энэ хэсгийг ингэж ... ярих хэрэгтэй гэх мэтээр зааварчилгаа өгөхийг сонсоод сандарч, тэвдэж байсан хэдий ч энэ урт, шахуу хөтөлбөртэй сургалтыг Күно багшийн тусламж дэмжлэгтэйгээр амжилттай дуусгаж чадлаа.” Күно багш, төслийн хамт олон, туслах ажилчид... гээд надад тусалж, хамтран ажилласан та бүхэнд талархал илэрхийлье хэмээн өөрийн сэтгэгдлийг илэрхийллээ.



Сургалтанд оролцогчид Тэрүя мэргэжилтэнд талархал илэрхийлэв.

~DET, Эхний төгсөлтийн сургагч багш нар давтлага сургалтанд хамрагдлаа~

4-р сарын 26-ны өдөр Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын эхний төгсөгчдөд зориулж давтлага сургалт зохион байгууллаа. Эхний төгсөгч нар 2016 оны 12-р сард сургалтанд хамрагдаж сургагч багш болсон бөгөөд өнөөг хүртэл нийтдээ 150 гаруй удаа DET сургалтыг зохион байгуулаад байна. Энэ удаа Япон дахь Жайкагийн төв оффисын мэргэжилтэн Күно багштай 1 жил хагасын дараа дахин уулзаж дасгал ажлуудын аргачлал, хэрхэн үр дүнтэй чиглүүлэх талаар суралцлаа. Оролцогчид “Хэрхэн чиглүүлэх тал дээр эргэлзээтэй байсан зүйлээ тодорхой болгож чадлаа”, “Өнөөдрийн хичээлээр маш олон зүйлийг ойлгож авлаа” хэмээн сэтгэл ханамжтай өгүүлж байлаа. Сургалтанд оролцогчид өөрсдийн ур чадварыг сайжруулж чадсан гэдэгт итгэлтэй байна.



Сургалтын үеэр

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com